



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/54

Булган сум

Сумын Засаг дарга, Засаг даргын  
Тамгын газрын үйл ажиллагаанд  
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай

Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11.1, 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Хутаг-Өндөр сумыг 5,000,000 (тав), 2 дугаар байр эзэлсэн Хангал сумыг 4,000,000 (дөрөв), 3 дугаар байр эзэлсэн Бугат сумыг 3,000,000 (гурав) сая төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2. Шагнал урамшуулалд шаардагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Өргөмжлөлд шаардагдах хөрөнгийг шагналын мөнгөнөөс суутгаж олгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ